



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

Жагсаалтад нэмэлт оруулах,
журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 10 дугаар зүйлийн 10.3, Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/245 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын жагсаалт”-ын “Нэгдүгээр бүлэг.Цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт”-ын жагсаалтын 4¹ дэх заалтад “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлыг зохион байгуулах /код 141/ журам” гэж нэмсүгэй.

2.“Байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлыг зохион байгуулах /код 141/ журам”-ыг хавсралтаар баталсугай.

3.Тушаалыг алба хаагчдаар судлуулж, мөрдүүлэх, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /цагдаагийн хурандаа О.Амарсанаа/-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Ж.БОЛД

1422 01 0722

Цагдаагийн ерөнхий газрын даргын
2022 оны 04 дугаар сарын 07-ны
өдрийн 04/07 дугаар тушаалын
хавсралт

УХГ0025

141.БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД АУДИТ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ	Батлагдсан:	Дугаар:
	Хавсралт:	Нэмэлт тайлбар:
Тараасан:	Шинэчилсэн:	Хуудас: 3

141.1.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

141.1.1.Энэхүү журам нь цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

141.2.ХАМРАХ ХҮРЭЭ, БАРИМТЛАХ БОДЛОГО

141.2.1.Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл /Дотоод аудит/, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын дотоод аудитын журам", дотоод аудитын олон улсын стандарт болон энэхүү журмыг баримтална.

141.2.2.Дотоод аудит нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөх үйл ажиллагаа бөгөөд системтэй, оновчтой, хараат бус арга хандлагаар байгууллагын эрсдэлийн удирдлага, засаглал, дотоод хяналтын үйл явцыг үнэлэх, сайжруулахад чиглэгдэнэ.

141.3.ДОТООД АУДИТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

141.3.1.Дотоод аудитыг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд цагдаагийн төв байгууллагын даргын баталсан дотоод аудитын ажлын жилийн төлөвлөгөө болон тухайлсан сэдвийн хүрээнд хэрэгжүүлэх дотоод аудит хийх удирдамжийг тус тус үндэслэнэ.

141.3.2.Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэр, зөвшөөрлөөр төлөвлөгөөт бус дотоод аудитыг зохион байгуулж болно.

141.3.3.Цагдаагийн төв байгууллагын даргын зөвшөөрөлгүй дотоод аудитын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

141.4.ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

141.4.1.Дотоод аудитын үйл ажиллагааг цагдаагийн төв байгууллагын дотоод аудит хариуцсан нэгж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, зохион байгуулна.

141.4.2.Цагдаагийн төв байгууллагын дотоод аудит хариуцсан нэгжийн дарга нь дотоод аудиторудын үйл ажиллагааг удирдах, хянах, нөөцийг үр дүнтэй зохион байгуулах, хуваарилалт хийж ажиллана.

141.4.3.Дотоод аудиторын багийг цагдаагийн төв байгууллагын дотоод аудит хариуцсан нэгжийн дарга ахалж, аудитын ажлыг төлөвлөх, гүйцэтгэх, тайланг бэлтгэх, аудиторын үйл ажиллагааг зохион байгуулах, цагдаагийн төв байгууллагын удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангана.

141.4.4.Дотоод аудитор нь багийн ахлагчаас өгсөн зааварчилгааны дагуу аудитын ажлын төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ажлын явцыг цаг тухайд нь тайлагнана.

141.4.5.Цагдаагийн төв байгууллагын дотоод аудит хариуцсан нэгж цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд алба, нэгжээс санал авч, нэгтгэн боловсруулж, жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор цагдаагийн төв байгууллагын даргаар батлуулах бөгөөд төлөвлөгөөний хагас жилийн тайланг 07 дугаар сарын 10-ны дотор, жилийн тайланг 12 дугаар сарын 15-ны дотор тус тус нэгтгэж, цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулна.

141.4.6.Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдлага дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг цагдаагийн төв байгууллагын дотоод аудит хариуцсан нэгжид тухай бүр хүргүүлнэ.

141.5.ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ХЭЛБЭР

141.5.1.Цагдаагийн төв байгууллагын дотоод аудит хариуцсан нэгж нь дотоод аудитын үйл ажиллагааг дараах төрлөөр хэрэгжүүлнэ:

а/Санхүүгийн дотоод аудит хийх;

б/Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтад дотоод аудит хийх;

в/Үйл ажиллагааны болон гүйцэтгэлийн аудит хийх.

141.5.2.Дотоод аудитын үйл ажиллагаа нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэртэй байна.

141.6.ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

141.6.1.Дотоод аудитын үйл ажиллагааг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

а/Төлөвлөлтийн үе шатанд:

1.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дотоод аудитын үйл ажиллагааг жилийн, ажлын гэсэн 2 төрлөөр төлөвлөж гүйцэтгэнэ.

2.Байгууллагын дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд тухайн жилд хийгдэх аудитын ажил, зарцуулах хугацаа, шаардлагатай нөөц зэргийг тусгаж батлуулна.

3.Цагдаагийн төв байгууллагын дотоод аудит хариуцсан нэгжийн дарга нь төлөвлөгөөнд тухайн аудитын ажлын зорилго, цар хүрээ, хугацаа болон нөөцийн хуваарилалт зэргийг тусгуулахад анхаарна.

б/Гүйцэтгэлийн үе шатанд:

1.Дотоод аудитор нь ажлын удирдамжид заасан хугацаанд багтаан дотоод аудитыг зохион байгуулна.

2.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ын 7 дугаар зүйлийг баримтлан дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.Дотоод аудитын ажлыг “Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт”-д нийцүүлэн боловсруулсан “Ажлын баримт”-ын дагуу хийж гүйцэтгэнэ.

4.Дотоод аудитын ажлыг гүйцэтгэх хугацаа нь тухайн ажлын цар хүрээ, нөхцөл байдал зэргээс хамаарна.

5.Дотоод аудитын ажлын үр дүнг хамрагдсан нэгжийн удирдлагад танилцуулж, холбогдох тайлбарыг дотоод аудитын тайланд хавсаргана.

6.Тодорхой шалтгааны улмаас удирдамжид заасан хугацаанд дотоод аудитыг гүйцэтгээгүй тохиолдолд цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулж, хугацааг сунгаж болно.

в/Тайлагнах үе шатанд:

1.Дотоод аудитын ажлын тайланг удирдамжид заасан хугацаанд, стандартын дагуу боловсруулах, цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулан шийдвэрлүүлнэ.

2.Удирдлагын шийдвэр бүхий тайлан, холбогдох зөвлөмжийг дотоод аудитад хамрагдсан нэгжийн удирдлагад хүргүүлэх, хэрэгжилтийг хангуулна.

141.7.БУСАД

141.7.1.Дотоод аудитын явцад гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл илэрсэн тохиолдолд харьяаллын дагуу шалгуулахаар холбогдох байгууллагад материалыг ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ.

141.7.2.Дотоод аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг тооцож, хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх, шийдвэрлүүлнэ.

---o0o---